



МОНГОЛ
УЛАСЫН
СЭХЭГ
ЭМЭГ
МЭДЭЭ
ХАМГААГАХ
ЯРИЙН
ЯРИЙН
ЯРИЙН

Илтгэлийн хураангуйд тавигдах шаардлага

1. Илтгэлийн хураангуйг 300 үгэнд багтаан бичнэ.
2. Илтгэлийн хураангуйн бүтэц:
 - Үндэслэл
 - Зорилго
 - Материал, арга зүй
 - Үр дүн
 - Дүгнэлт
 - Түлхүүр үг: Судалгааны гарчигт ороогүй 3-5 үг байна.
 - Хураангуйд 1 хүснэгт, 1 зураг оролцуулж болно
3. Илтгэлийн нэр: Arial шрифтээр, том үсгээр /UPPERCASE/, 12pt (size) хэмжээтэй, Bold
4. Судалгааны багийн гишүүдийн нэр, албан байгуулга, e-mail хаяг: Arial шрифтээр, 11 үсгийн хэмжээтэй, Italic

Жишээ нь:

A.Aaa¹, B.Bbb², V.Vvv³

¹АШУУИС, Анагаах ухааны сургууль, Мэс заслын тэнхим

²АШУУИС, Био-Анагаахын сургууль, Анатомийн тэнхим

³УНТЭ, Мэс заслын тасаг

5. Дэд гарчиг Arial (font) фонттой, 12pt (size) хэмжээтэй, зүүн тал руу (align left) шахсан байна.
6. Эх бичвэр: Догол мөрнөөс (tab-1cm) эхэлж бичих бөгөөд мөр хоорондын зай 1.5, Arial (font) фонттой, ердийн загвартай (regular style), 12pt (size) хэмжээтэй, баруун зүүн талуудыг тэгшилсэн (Justified) байна.



Эмнэлзүйн тохиолдлын хураангуйд тавигдах шаардлага

1. Эмнэлзүйн тохиолдлын хураангуйг 300 үгэнд багтаан бичнэ.
2. Эмнэлзүйн тохиолдлын хураангуйн бүтэц:
 - Товч утга
 - Оношилгоо
 - Эмчилгээ
 - Эмчилгээний үр дүн
 - Дүгнэлт
 - Түлхүүр үг: Гарчигт ороогүй 3-5 үг байна.
 - Хураангуйд 1 хүснэгт, 1 зураг оролцуулж болно
3. Тохиолдлын нэр: Arial шрифтээр, том үсгээр /UPPERCASE/, 12pt (size) хэмжээтэй, Bold
4. Судалгааны багийн гишүүдийн нэр, албан байгуулга, e-mail хаяг: Arial шрифтээр, 11 үсгийн хэмжээтэй, Italic

Жишээ нь:

A.Aaa¹, Б.Ббб², В.Ввв³

¹АШУУИС, Анагаах ухааны сургууль, Мэс заслын тэнхим

²АШУУИС, Био-Анагаахын сургууль, Анатомийн тэнхим

³УНТЭ, Мэс заслын тасаг

5. Дэд гарчиг Arial (font) фонттой, 12pt (size) хэмжээтэй, зүүн тал руу (align left) шахсан байна.
6. Эх бичвэр: Догол мөрнөөс (tab-1cm) эхэлж бичих бөгөөд мөр хоорондын зай 1.5, Arial (font) фонттой, ердийн загвартай (regular style), 12pt (size) хэмжээтэй, баруун зүүн талуудыг тэгшилсэн (Justified) байна.

Жишээ нь

АЖ АХУЙН НЭГЖИЙН АЖИЛЧДЫН ДУНД БҮРТГЭГДСЭН ХООЛНЫ ХОРДЛОГОТ ХАЛДВАРЫН ДЭГДЭЛТИЙН СУДАЛГАА

Г.Хоролгарав¹, Р.Амгалан², Л.Шижир², Л.Пүрэвсод¹,
Б.Мөнх-Ундрах¹, Э.Энэрэл¹, Ж.Нямсүрэн², Ж.Байгальмаа²,
Р.Оюунгэрэл¹

¹Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль


²Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв
khorolgarav@mnums.edu.mn

Үндэслэл: ДЭМБ-ын (2021) судалгаагаар өндөр орлоготой орнуудад, насанд хүрэгчдийн дунд *E. coli*-ийн шалтгаант суулгалт халдвар 100 000 хүн тутамд 48, нас баралт (CFR) 12.4% байна.

Зорилго, зорилт: Аж ахуйн нэгжийн ажилчдын дунд бүртгэгдсэн хоолны хордлогын дэгдэлтийг судлах

Материал, арга зүй: Судалгааг Монгол улсад худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн 114 ажилчдад хоолны хордлогын эмнэлзүй илэрснийг дескриптив болон эргэмж когорт судалгааны аргаар судлав. Үр дүнг ANOVA болон post-hoc тест, ашиглан SPSS-28 программын тусламжтайгаар шинжилж p утга <0.05 үед статистик үнэн магадлалтай гэж үзсэн.

Үр дүн: Өвчлөгсдийн дундаж нас 33.1 ± 10.9 , эмэгтэйчүүд 68.4%(78) байсан. Дэгдэлтийн муруйг дүгнэхэд нэг эх уурхайгаас улбаатай дэгдэлт байсан ба эхний тохиолдол хоол идсэнээс 10 минутын дараа бүртгэгдсэнээс хойш 4-6 цагийн дараа дэгдэлт оргилд хүрчээ (Зураг 1). Сүүлийн 3 хоногт "харчо" шөл хэрэглэсэн хүмүүсийн халдварт өртсөн эрсдэл шөл хэрэглээгүй тохиолдлоос 5 дахин(OR, $p < 0.05$) их байв. Эмнэлзүйн хувьд дотор муухай оргих 78%(89), гэдэс дүүрэх 54% (61) шинжүүд зонхилон ажиглагдсан. Өвчлөгсдийн шулуун гэдэсний арчдас, бөөлжис, өтгөнд нян судлалын шинжилгээ хийхэд 2.2%(2)-д *Enterococcus*, 5.7%(5)-д *Campylobacter* spp, 1.1% (1) дээрх 2 эмгэгтөрөгч илэрсэн. Хоолны дээжийн 32 сорьцын 21.8%(7)-д гэдэсний бүлгийн эмгэг төрөгч *Enterobacter* spp илэрсэн.



Дүгнэлт: Аж ахуйн нэгжийн ажилчдын дунд гэдэсний бүлгийн эмгэгтөрөгч нянгаар (*E.coli*, *Campylobacter* spp) үүсгэгдсэн хоолны хордлогот халдварын дэгдэлт бүртгэгдсэн байна.

Түлхүүр үг: *E.coli*, дэгдэлт, нян судлал

АШУУИС-ИЙН МОНГОЛ - ЯПОН ЭМНЭЛЭГТ МАММОГРАФИ ХИЙЛГЭСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨХНИЙ ЭДИЙН НЯГТШИЛЫН НАСНЫ ХАМААРЛЫГ СУДАЛСАН НЬ

П.Төгсжаргал^{1,2}, Б.Халиун², Р. Энжин², Ц.Эрдэмбилэг¹,
С.Энэбиш³, Д.Түвшинжаргал^{1,2}

¹АШУУИС, Анагаах Ухааны Сургууль Радиологийн Тэнхим

²АШУУИС-ийн Монгол Япон Эмнэлгийн Радиологийн тасаг

³АШУУИС-ийн Био Анагаахын Сургууль, Анатомийн Тэнхим
tugsjargal@mnums.edu.mn

Үндэслэл: Монгол улсад хөхний өмөнгөөр өвчлөгсдийн 1/4 (25.1%) эхний шатандаа оношлогдсон ч маммографийн хөхний өмөнг илрүүлэх индексийн мэдрэг байдал 63%- 98% хэлбэлздэг. Д. Дэлгэрмаа, Мелло-Томс нар "Монгол орны маммографийн шинжилгээний төрх байдал: Хөхний нягтшилын ялгаатай байдлын шалтгаан хүчин зүйлүүд" хэмээх 2017 оны хийсэн судалгаанд Монгол Улсын Хавдар Судлалын Үндэсний Төвөөс 16-83 насны 1985 эмэгтэйг сонгон авч судлахад В ангиллын нягтшилтай хөх 12 (33%) нь буюу хамгийн нийтлэг байсан бол эмэгтэйчүүдийн А-25%, С-18%, D-24% тус тусдаа ангилагдаж байсан.

Зорилго: АШУУИС-ийн Монгол-Япон эмнэлэгт маммографийн шинжилгээ хийлгэсэн эмэгтэйчүүдийн хөхний эдийн нягтшилын зэргийг насны бүлэгтэй харьцуулан судлах
Материал, арга зүй: АШУУИС-ийн Монгол-Япон эмнэлэгт 2021-2023 маммографийн шинжилгээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн зургуудад хөхний фиброгландуляр эдийн нягтшилыг тодорхойлж, насны бүлэгтэй холбон дескриптив судалгааг гүйцэтгэсэн. Маммограммын зургийг BIRADS (Breast Imaging Reporting and Data System) оноогоор дараах байдлаар үнэлсэн. Үүнд:

А. Өөх давамгайлсан (fatty) нягтшил 25%-с бага

В. Булчирхайн фиброз нягтшил (scattered fibroglandular dense)- 25-50%

С. Жигд бус нягтшил (heterogeneously dense)-51-75%

D. Өндөр нягтшил (hyperdense) -75%-с дээш

Үр дүн: 2021-2023 онуудад АШУУИС-ийн МЯЭ-д маммографийн шинжилгээнд нийт 1742 эмэгтэйчүүд хамрагдсан. Хөхний эдийн нягтшил өндөр байх BIRADS D бүлэг нь 20-29 насныханд 48.1%-д, 30-39 насныханд 24%-д илэрсэн.

Дүгнэлт: Эмэгтэйчүүдийн нас ахих тусам хөхний эдийн өөхжилт нэмэгдэж, нягтшил ихтэй бүлгийн хувь багасаж байна. Дөчин наснаас доош эмэгтэйчүүдэд өөх давамгайлсан нягтшил бусад орны эмэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр тохиолдож байна.

Түлхүүр үг: BIRADS, өөх давамгайлсан хөх, хөхний өмөн

Нас	А		В		С		D		Нийт
	N	%	N	%	N	%	N	%	
20-29	0	0	22	14.8	54	37.1	72	48.1	148
30-39	69	17	126	31	116	28	95	24	406
40-49	154	25	308	50	136	23	13	2	611
50-59	184	48.4	184	48.4	12	3.2	0	0	380
60+	138	70	59	30	0	0	0	0	197
Нийт	545	31.3	699	18.2	318	18.2	180	10.3	1742